

- 4.5. Аж ахуйн болон хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чигэлээр үйл ажиллагааны хүрээнд:
- 4.5.1. Холбооны бэлгэдэл, нэр, таних тэмдэг болон зохиогчийн эрхийн холбогдолтой оюуны бүтээл, брэндийг хууль тогтоомжийн хүрээнд сурталчилж, таниулах, худалдан борлуулах, олсон орлогыг дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд ашиглах;
 - 4.5.2. Монголын Уулчдын Үндэсний Холбооны тэмцээн болон бусад тэмцээн, уралдааныг дамжуулах, сурталчилах, аудио, видео, фото хэрэгсэл, бусад технологийг ашигласан бичлэг, сурталчилгааны материалыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдтэй хамтран ашиглах, зарж борлуулах эрхийг эдлэх;
 - 4.5.3. Холбооны үйл ажиллагаа, уулын спортыг бүх талаар сурталчилдаг, байнгын ажиллагаатай вэб хуудсыг интернэтэд байрлуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол сурталчилах;
 - 4.5.4. Жил бүр нэгдсэн төлөвлөгөө баталж, орон нутагт уулын спортыг сурталчилах;
 - 4.5.5. Хууль болон энэ дүрмээр зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа эрхлэх.

ТАВ. ХОЛБООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 5.1. Холбооны удирдлагын тогтолцоо нь Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Ажлын алба, Мэргэжлийн зөвлөл, Хяналтын зөвлөлөөс бүрдэнэ.

Бүх гишүүдийн хурал:

- 5.2. Холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.
- 5.3. Холбооны бүх гишүүдийн хурал ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.
- 5.4. Бүх гишүүдийн ээлжит хурлыг 4 жилд нэг удаа хуралдуулна. Энэ хугацаанд бүх гишүүдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй тохиолдолд, удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болж, хурлыг нийт гишүүдийн 25-аас дээш хувийн санаачлага, эсхүл Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.
- 5.5. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болох бөгөөд нийт гишүүдийн 50-аас дээш хувь, Удирдах Зөвлөлийн нийт гишүүдийн 1/3-ийн хувийн санал эсхүл Ерөнхийлөгчийн санаачлагаар зарлан хуралдуулж болно.
- 5.6. Бүх гишүүдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:
 - 5.6.1. Холбооны дүрмийг батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 5.6.2. Холбооны 4 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;
 - 5.6.3. Ерөнхийлөгч, Удирдах Зөвлөлийн болон Хяналтын Зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн тайланг хэлэлцэх;
 - 5.6.4. Холбооноос явуулах үндсэн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
 - 5.6.5. Хяналтын зөвлөлийн санал дүгнэлтийг хэлэлцэх;
 - 5.6.6. Холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах.

Удирдах зөвлөл: